



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 01/60

Чингис хот

Л.Мэндбаярыг хөдөлмөрийн гэрээгээр  
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.2.2, 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн бэлэн байдал зарлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийн дагуу ажлын зайлшгүй шаардлагаар Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Л.Мэндбаярыг Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм цуцлагдах хүртэл хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнгэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Г.Лхагвахатан Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Г.Уянга Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Д.Наранмичид Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга

Ч.Оюун-Эрдэнэ Нярав

3. Л.Мэндбаярын цалинг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу 871230 /найман зуун далан нэгэн мянга хоёр зуун гуч/ төгрөгөөр, бусад нэмэгдлийг тооцож олгохыг Эрүүл мэндийн газрын газрын нягтлан бодогч /М.Дагва/-д зөвшөөрсүгэй.

4. Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Л.Мэндбаярт үүрэг болгосугай.

5. Л.Мэндбаярт томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011026